Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **Зорилго 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана.** | | | | | | | | |
| Зорилт 1. Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн чадавхыг дээшлүүлнэ | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 /2.13/<br><br>Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст орж ажиллах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст нарийн бичгийн даргын үүргээр орж ажилласан. Үүнд:<br><br>1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн захиргааны нэгдсэн байрны 9 дүгээр давхарт байрлах 207.63 м.кв “Цайны газар”-ын зориулалттай талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс;<br>2. Нийслэлийн Ерөнхий боловсролын 168 дугаар сургуулийн 1 давхарт байрлах 353.5 м.кв “Сургуулийн цайны газар”-ын зориулалттай талбайг түрээслэх түрээслэгчийг болон “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах комисс<br>3. Нийслэлийн Өргөө амаржих газрын байранд байрлах 172.1 м.кв талбайг “Цайны газар”-ын зориулалтаар түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс;<br>4. Сүхбаатар дүүргийн 6 хорооны нутаг дэвсгэрт байршилтай Нийслэлийн Өмчийн харилцааны газрын балансад бүртгэлтэй “Сувилал, сургалт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрдэм шинжилгээний судалгааны төв”-ийг үнэлэх үнэлгээний байгууллагыг сонгон шалгаруулах комиссын гишүүн;<br>5. Нийслэлийн өмчийн 4 обьектийг хамгаалалтад авах хамгаалалтын компанийг сонгон шалгаруулах комиссын гишүүнээр тус тус оролцоод байна.<br>6. Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн 1 давхарт байрлах цайны газрын зориулалтаар түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст нарийн бичгийн даргаар ажилласан.<br>7. “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-ын 1 давхарт байрлах 29 м.кв “Цайны газар”-ын зориулалттай талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст орж ажилласан.<br>8. Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төвийн харьяа нийтийн аж ахуйн үйлчилгээний төвийн байранд 65,9 мкв талбайг “Клуб”-ний зориулалтаар түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст нарийн бичгийн даргаар ажилласан.<br>9. Нийтийн тээврийн бодлогын газрын балансt бүртгэлтэй Шархадны автобусны буудлын эцсийн зогсоолын 96.9 м.кв талбайг болон Улиастайн автобусны буудлын эцсийн зогсоолын 136 м.кв талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс;<br>10. Хүрээ амаржих газрын шинэ эмнэлгийн барилгын гадна байрлах 30 авто машины зогсоол бүхий 288 м.кв “Авто машины зогсоол”-ын зориулалттай талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах | |
| | | | | | | | Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах дараах ажлын хэсгийн комисст гишүүний үүргээр орж ажилласан. Үүнд: | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1. Мөн СБД-ийн 6 хорооны нутаг дэвсгэрт байршилтай НӨХГ-ын балансад бүртгэлтэй “Сувилал, сургалт эрдэм шинжилгээний судалгааны төв”-ийг үнэлэх үнэлгээний байгууллагыг сонгон шалгаруулах комиссын гишүүн;<br>2. Нийслэлийн өмчийн 4 обьектийг хамгаалалтад авах хамгаалалтын компанийг сонгон шалгаруулах комиссын гишүүн;<br>3. ХУД-ийн Эрүүл мэндийн төвийн эмийн сангийн зориулалтаар түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс-д гишүүнээр тус тус оролцоод байна. | |
| 2. | Арга хэмжээ 1.2 /2.25/<br><br>Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох; | | Шүүхийн маргааны тоо,<br><br>Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо | 0% | 3 | 4 | НИТХ, НЗД-ыг төлөөлөн оролцож байгаа 4 хэрэг байна. Үүнд:<br><br>1. **Нэхэмжлэгч:** **“** Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв **” ХХК, Хариуцагч:** НИТХ, НЗД, НӨХК дарга<br><br>**Нэхэмжлэлийн шаардлага**: 1.НИТХ-ын 2025 оны 25/35 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах;<br>2.ЗХАШШ 20 дугаар шүүхийн 2014 оны 620 дугаар шийдвэрийг биелүүлэхгүй байгаа НӨХК-ийн эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох;<br>3. НИТХ-ын 2025 оны 25/77 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах;<br>4. НЗД-ын 2025 оны А/84 дугаар захирамжийг хүчингүй болгуулах;<br>Шүүх хурал 3 удаа хойшилсон. Дараагийн хурал 2025 оны 12 сарын 08-ны өдрийн 10 цагт товлогдсон.<br>2. **Нэхэмжлэгч: “**“Наранбулаг сервис” ХХК, “Бадрал” ХХК, **Хариуцагч:** НИТХ, НЗД, НӨХГ<br>**Нэхэмжлэлийн шаардлага**:<br>1.НИТХ-ын 2025 25/101 дугаар тогтоол илт хууль бус болохыг тогтоолгох;<br>2.ЧД 5 дугаар хороонд байрлах Баруун Сэлбэ үйлчилгээний төвийн "Нарны титэм" барилгын Ж блокын 175 м.кв, 155 м.кв талбай бүхий хэсгийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монгол улсын Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д заасан нөхцөлөөр "Наранбулаг сервис" ХХК, “Бадрал" ХХК-д тус тус хувьчлах асуудлыг шийдвэрлэсэн хүчин төгөлдөр хэвээр байгаа НИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 20/21 тоот тогтоолыг хэрэгжүүлэхгүй байгаа Нийслэлийн Засаг даргын эс үйлдэхүйг хууль бус" болохыг тогтоолгох;<br>3. Хүчин төгөлдөр хэвээр байгаа НИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 20/21 тоот тогтоолыг хэрэгжүүлж, "Наранбулаг сервис" ХХК, “Бадрал" ХХК-д тус тус хувьчлахыг НИТХ-д бодит, үнэн зөвөөр танилцуулж, шийдвэрлүүлэхийг НЗД-д даалгах<br>2025 оны 10 сарын 29-нд шүүх хурал болж хариуцагчийн зүгээс “Ажбогд” ХХК-ийг гуравдагчаар оролцуулах хүсэлт гаргасан. Шүүх хүлээн авснаар дараагийн хурлыг 2025 оны 12 сарын 09-ний өдөр 13:30-д товлогдсон.<br>3. **Нэхэмжлэгч:** С.Пүрэвжав, С.Мягмарсүрэн, **Хариуцагч:** НӨХГ, НЗД, НӨХК<br><br>**Нэхэмжлэлийн шаардлага**: 1. НӨХК-ийн 2024 оны 02 дугаар Өмчлөгчийн эрх олгох тухай тогтоолыг хүчингүй болгуулах<br>2. Өмчлөгчийн эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулах. Шүүх хурал товлогдоогүй байна.<br><br>4. **Нэхэмжлэгч:** С“Лхатоном” ХХК, **Хариуцагч:** НӨХГ, НИТХ<br><br>**Нэхэмжлэлийн шаардлага**: НИТХ-ын 2025 оны 25/58 тогтоолыг хүчингүй болгуулах. Шүүх хурал 2 удаа зарлагдсан хойшилсон. Одоогоор товлогдоогүй байна. | |
| 3. | Арга хэмжээ 1.3 /2.26/<br><br>Нийслэлийн өмчид хохирол учруулсан, үрэгдүүлсэн, шамшигдуулсан, гэрээний | | | | | | Тус газрын балансад бүртгэлтэй, нийслэлийн өмч болох 15 объекттой холбоотойгоор өмчлөл, эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлж, хууль бус байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар Нийслэлийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | заалтыг зөрчсөн зэрэг өмч хөрөнгийн холбогдолтой асуудлыг хяналт шалгалтын байгууллагаар шийдвэрлүүлэх, шүүхийн маргаанд нэхэмжлэгчээр оролцох; | | Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо | 15 | 7 | 9 | Прокурорын газарт өргөдөл, гомдлыг гаргасан. Нийслэлийн Прокурорын газраас дараах асуудлуудыг Авлигын эсрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байдлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн ажилласан. Үүнд:<br><br>1. **<u>Прокурорын тогтоолоор хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан:</u>**<br>1) Монголын Бурхан Шашинтны шинэ төвийн тэргүүн С.Санждорж нь Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дамбадаржайлин хийдийн Цогчин дуган А, Б, В блок барилгыг чөлөөлж, хүлээлгэн өгөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэлд хэрэг бүртгэлтийн 240200420 дугаартай хэргийг НПГ-ын 2024 оны 12 сарын 20-ны өдрийн Д392 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2. дахь заалтад заасан **"гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан"** үндэслэлээр хаасан байна.<br><br>Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газрын эрх бүхий албан тушаалтнууд нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Нийслэлийн өмчийн харилцааны газрын балансд бүртгэлтэй Москва рестораны баруун талд байрлах хуучнаар шуудангийн 24 дүгээр салбарын 198 м.кв бүхий үйлчилгээний зориулалттай барилга дээр 2 давхар барилгыг нэмж барих зөвшөөрлийг олгож бусдад давуу байдал бий болгосон байж болзошгүй гэх хэрэгт хэрэг бүртгэлтийн 240200428 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 06 сарын 25-ны өдрийн Д209 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан **"гэмт хэргийн шинжгүй"** үндэслэлээр хаасан байна. | 100% |
| | | | | | | | 2) Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо "Монгол шуудан" ХК-ийн 36 дугаар салбарын байрыг нийслэлийн өмчийн газрын балансаас ямар нэг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэргүйгээр хасагдсан байгаа нь холбогдох хууль, журам зөрчсөн байдалд хэрэг бүртгэлтийн 240200421 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 01 сарын 20-ны өдрийн Д19 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан **"гэмт хэргийн шинжгүй"** үндэслэлээр хаасан байна.<br><br>Баянгол дүүрэг, 7-р хороо, "Эрхэм жаргалан" өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга болон Баянгол дүүрэг, 14-р хороо Москва ресторанны баруун талд байрлах объектыг тус тус "Тэмүүжин групп" ХХК-д эзэмшүүлж, ашиглуулсан, давхар түрээслэж ашиг олсон үйлдэлд хэрэг бүртгэлтийн 240200423 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 01 сарын 27-ны өдрийн Д24 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан **"гэмт хэргийн шинжгүй"** үндэслэлээр хаасан байна. | |
| | | | | | | | 3) Нийслэлийн өмчийн барилга болох Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, 1а байрны 1 тоотод байрлах өрхийн эмнэлгийн байрыг "Ачит гар" өрхийн эмнэлэг нь хийц бүтээцийг зөвшөөрөлгүй өөрчилсөн, байр чөлөөлөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэлд хэрэг бүртгэлтийн 240200443 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 02 сарын 07-ны өдрийн Д34 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан **"гэмт хэргийн шинжгүй"** үндэслэлээр хаасан байна.<br>4) Ерөнхий сайд Жигжид-жавын байранд "Монгол Улсын Нутгийн удирдлагуудын холбоо" ТББ гэрээгүйгээр үйл ажиллагаа явуулдаг асуудалд хэрэг бүртгэлтийн 240200427 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 02 сарын 07-ны өдрийн Д36 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан **"гэмт хэргийн шинжгүй"** үндэслэлээр хаасан байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нийслэлийн орон сууц хувьчлах товчооны эрх бүхий албан тушаалтан нар нь албан үүрэг, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Нийслэлийн өмчид бүртгэлтэй СБД, 7-р хороо, 11-р хороолол, 6-р байр, 2-р орц 40 тоот орон сууцыг хууль бусаар хувьчилсан байж болзошгүй гэх хэрэгт хэрэг бүртгэлтийн 240200419 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 11 сарын 11-ний өдрийн Д354 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан **"гэмт хэргийн шинжгүй"** үндэслэлээр хаасан байна. | |
| | | | | | | | **2. <u>Мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэрэг:</u>**<br>1) ХУД, 22 хороо, Ар зайсангийн гудамж-1/Зайсангийн аманд/ байрлах барилга газрыг Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийг Ж.Хатанбаатарт менежментийн гэрээгээр хувьчлахаар гэрээ байгуулж, үйл ажиллагаа явуулсан асуудалд;<br>2) БГД, 8-р хороо, "Аминжаргалан" ӨЭМТ-ийн хуучин барилгыг Иргэн Б.Ганцогт бусдад дамжуулан Чин Гэгээн өргөө ӨЭМТ-д түрээсэлсэн асуудалд;<br>3) БГД, 14-р хороо Москва ресторany баруун талд, түрээсийн гэрээтэй, "Тэмүүжин майнинг групп" ХХК түрээсийн гэрээ байгуулан, үйл ажиллагаа явуулдаг байсан асуудалд;<br>4) ХУД, 22 хороо, ЗДТГ-ын балансt бүртгэлтэй, богд уулын аманд байрлах байр, ХУД, 4-р хороо, Нийслэлийн Төр захиргааны Яармагийн шинэ цогцолборт "Их үйлсийн хишиг" ХХК-тэй байгуулсан 2023 оны түрээсийн гэрээг батлагдсан загварын дагуу хийгээгүй асуудалд;<br>5) СХД, 20-р хороо, Хүнсчдийн гудамжны 3А, Орбитын орон сууцны дунд байрлах 1 давхар тоосгон барилга, газар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ иргэн С.Батчулууны нэр дээр гарсан асуудалд;<br>6) СХД, 14-р хороо, 1-р хороолол, 14-8-253 тоот, Иргэн О.Сүрэнхорлоо Үл хөдлөх эд хөрөнгө | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өмчлөх эрхийн улсын бүртгэлийн Ү-2201020811 гэрчилгээ гарсан асуудалд;<br>7) БГД, 14-р хороо, 3 хороолол 18-30, Иргэн П.Цогтбаатар Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн Ү-2205082124 гэрчилгээ гарсан асуудалд;<br>8) СБД-ийн 6 хороо, Бага тойруу гудамж, Эмийн үйлдвэрийн барилгыг Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвд “орон сууц, үйлчилгээ”-ний зориулалтаар 5 жилийн хугацаатай эзэмшүүлсэн асуудалд;<br><br>ХУД, 4-р хороо, Нийслэлийн Төр захиргааны Яармагийн шинэ цогцолбор барилгад талбайг “Их үйлсийн хишиг” ХХК-тэй байгуулсан 2023 оны түрээсийн гэрээг батлагдсан загварын дагуу хийгээгүй үйлдэл. | |
| 4. | Арга хэмжээ 1.4 /2.27/<br><br>Өмчийн харилцааны зөрчил маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагад хянан шийдвэрлэхэд төлөөлөн оролцох, шүүхэд тайлбар, холбогдох нотлох баримт гаргаж өгөх, мэдээ тайлан гаргах | | Шүүхийн маргааны тоо,<br><br>Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо | 0% | 50% | 100% | Нийслэлийн өмчийн харилцааны газрыг төлөөлөн оролцож хууль хяналтын байгууллагад хянагдаж байгаа 6 хэрэг байна. Үүнд:<br><br>1. **Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: Б.Ганцогт**<br>Шүүх хурал ХУД-ийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 09 сарын 18-ны өдрийн Д192/ШШ2025/07349 дугаар шийдвэрээр хариуцагчаас 9,338,395.0 төгрөгийг нэхэмжлэгчид гаргуулахаар шийдвэрлэв. Нийслэл дэх иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хурал 2025 оны 11 сарын 17-ны өдөр болж ХУД-ийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 09 сарын 18-ны өдрийн Д192/ШШ2025/07349 дугаар шийдвэрийг хэвээр үлдээсэн. Шүүхийн магадлал ирээгүй байна.<br>2. **Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: “Ачит гар” ӨЭМТ**<br>Шүүхэд нэхэмжлэгч нэхэмжлэлээс татгалзах хүсэлт гаргасан байна.<br>3. **Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: Г.Алтантуяа** | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Түрээслэгч Г.Алтантуяа нь 2024 онд НӨХГ-тай байгуулсан Түрээсийн гэрээний төлбөр болох 5,588,100.0 төгрөгийн төлөөгүй түрээсийн үлдэгдэл төлбөрийг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг БЗ, СБД, ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд гаргасан болно.<br>**4. Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч:"Хоёр сайхан хайрхан" ХХК**<br>2024 онд НӨХГ-тай Түрээсийн гэрээ байгуулсан "Хоёр сайхан хайрхан" ХХК нь төлөх ёстой байсан түрээсийн төлбөрөөс 1,026,000.0 төгрөг төлбөрийг дутуу төлсөн байх тул БЗ, СБД, ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан болно. | |
| | | | | | | | **5. Нэхэмжлэгч: "Материал Импекс" ХК, Хариуцагч: НӨХГ**<br>Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. 2025 оны 11 сарын 24-нд шүүх хурал хойшилсон. Тов зарлагдаагүй байна.<br>**6. Нэхэмжлэгч: "Улаанбаатар Радио" ХХК, Хариуцагч: НӨХГ**<br>2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр иргэний хэрэг үүсч, 2025 оны 05 сарын 22-ны өдөр нэхэмжлэгч "Улаанбаатар Радио" ХХК-ийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан хүсэлтийн дагуу шүүх 2025 оны 09 сарын 09-ний өдрийн 191/ШШ2025/05246 дугаар захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгосон. | |
| 5. | Арга хэмжээ 1.5 /2.28/<br><br>Нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил, маргааныг зохицуулах, шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | Энэ арга хэмжээний хүрээнд Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Х.Батчимэг, прокурор Я.Болортуяа нартай уулзалт хийж, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдээс үлдэгдэл төлбөрийг нэхэмжлэх, шүүхэд үлдэгдэл төлбөрийг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэл гаргах ажлуудыг шат дараалан хэрэгжүүлэх ажлын хүрээнд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамтран ажиллан, төр нийтийн ашиг сонирхолыг хамгаалж өгөхийг хүссэн 1/765 дугаар албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлэн ажилласан. Энэхүү ажлын үр дүнд нийслэлийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх ач холбогдолтой юм.<br>Мөн Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн прокурор Я.Болортуяа НӨХГ-ын нэхэмжлэлтэй, иргэн Б.Ганцоггод холбогдох иргэний хэрэгт бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцосон. | |
| 6. | Арга хэмжээ 1.6 /2.29/<br><br>Холбогдох хууль тогтоомжийн төсөлд санал оруулах, өмчтэй холбоотой хууль, дүрэм, журмыг сурталчлан, арга зүйгээр хангах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | ***1) <u>1/516 /2025-04-02/</u>***<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл;<br>***2) <u>1/42 /2025-01-16/</u>***<br>“Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төсөл;<br>***3) <u>1/515 /2025-03-31/</u>***<br>Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хууль<br>***4) <u>1/723 /2025-05-07/</u>***<br>Худалдан авах ажиллагааны тухай хууль<br>***5) <u>1/729 2025-05-07/</u>***<br>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<br>***6) <u>1/752 /2025-05-13/</u>***<br>Арилжааны тухай хууль<br>7) ***<u>1/773 /2025-05-14/</u>***<br>“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн төсөл;<br>***8) <u>1/780 /2025-05-19/</u>***<br>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл;<br>***9) <u>1/653 /2025-04-21/</u>***<br>Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ***10) 1/800 /2025-05-22/***<br>Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл;<br>***11) 1/1651 2025-09-26***<br>“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн төсөл<br>**12) 1/*1741 2025-10-06***<br>“Эдийн засгийн эрх чөлөөний тухай” хуулийн төсөл<br>13) 1/1899 2025-10-22<br>“Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай” анхдагч хуулийн төсөл<br>***14) 1/2121 2025-11-17***<br>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<br>***15) 1/2146 2025-11-23***<br>Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрмийн төсөл. | |
| 7. | Арга хэмжээ 1.7 /2.30/<br><br>НИТХ-ын тогтоол, нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдан нийслэлийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа нийслэлийн өмчийн эрх зүйн акт, дүрэм, тогтоол, журмуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | ***1) /2025-01-16/ ЦАХИМААР***<br>“Нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчаас нийслэлийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээ”-ний төсөлд санал<br>***2) 1/42 /2025-01-16/***<br><br>“Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төсөлд санал | 70%<br>100% |
| 8. | Арга хэмжээ 1.8 /2.20/<br><br>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурал зохион байгуулах; | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | НӨХГ-ын даргын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/126 дугаар тушаалаар ҮХХХК-ийн бүрэлдэхүүнийг баталж, комиссын даргаар ХЗХ-ийн дарга Б.Баясалмаа миний бие томилогдон ажиллаж эхэлсэн. ҮХХХК-ийн 4-12 дугаар хурлаар нийт 696 хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу 80,620,876,655.69 төгрөгийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг хийх шийдвэр гаргасан. Үүнд:<br>1. ***Хөрөнгө шинээр бүртгэх*** 105 хуулийн этгээдийн 5,741,076,726.48 төгрөг; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. **Балансаас балансад шилжүүлэх** 78 хуулийн этгээдийн 17,900,531,555.49 төгрөг;<br>3. **Данснаас дансанд шилжүүлэх** 20 хуулийн этгээдийн 854,193,640.15 төгрөг;<br>4. **Дахин үнэлэх** 152 хуулийн этгээдийн 23,105,723,132.50 төгрөг;<br>5. **Данснаас хасах** 341 хуулийн этгээдийн 33,019,351,601.07 төгрөг. | |
| **Зорилго 3. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт 2. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна. | | | | | | | | |
| 9. | Арга хэмжээ 2.1 /3.1/<br><br>Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | Байгууллагын үйл ажиллагааг хангах зорилгоор батлан гаргаж байгаа бүх төрлийн баримт бичгийн төслийг өдөр тутам хянаж, хууль зүйн үндэслэлийг зөв бичих, жигдрүүлэхэд анхаарч, албан хаагчдыг хууль зүйн зөвлөгөө мэдээллээр тогтмол хангаж ажиллаж байна. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хэмжээнд хийгдсэн гэрээ болон тушаалын тоог харуулбал */гэрээний мэргэжилтэн ирүүлснээр/*:<br>**I. Гэрээ-411**<br>- Шууд гэрээ (34)<br>- Дам гэрээ (306)<br>- Үдийн цайны газрын гэрээ (71)<br>**II. Тушаал-68**<br>- Б тушаал (68) | 100% |
| 10. | Арга хэмжээ 2.2 /3.2/<br><br>Хяналт шалгалтын байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | 1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 1/798 дугаарт албан бичгээр "2025 оны эхний хагас жилд хийсэн эрх зүйн үйл ажиллагааны тайлан" илгээсэн.<br>2. Нийслэлийн иргэлийн Төлөөлөгчдийн хуралд 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 1/472 дугаарт албан бичгээр НИТХ-ын Зөвлөлийн 2025 оны 07 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг даалгаварын дагуу НӨХГ-ын үйл ажиллагаа, нийслэлийн өмчийн талаарх мэдээлэл болон 2025 онд хувьчлах эд хөрөнгийн талаарх танилцуулга бэлтгэн хүргүүлсэн. Тус бэлтгэсэн материалыг | 100%<br>90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | НИТХ-ын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хорооны дарга, гишүүдэд НӨХГ-ын дарга танилцуулсан.<br>3. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын албан хаагчид Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газраас 2025 оны 05 сарын 05-ны өдрөөс 05 сарын 09-ний өдрийн хооронд зохион байгуулсан “Төрийн болон Орон нутгийн өмчийн харилцааны салбарын нэгдсэн сургалт”-д НӨХГ-ын 2024 оны ажлын тайлан, танилцуулгыг бэлтгэж, илтгэл тавьж хэлэлцүүлсэн.<br>4. НЗД-ын 2025 оны А/1297 байгуулагдсан ажлын хэсгийн 2-р хуралд Хүнс хангамжийн 4 ОНӨААТҮГ-ын танилцуулгын бэлтгэж, танилцуулга хийсэн.<br>5. НЗД-ын 2025 оны А/1530 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаас “Дамбадаржаа” ОНӨААТҮГ байгуулах болсон тул НИТХ-д өргөн барих тогтоолын төслийг үүсгэн байгуулах дүрмийн хамт бэлтгэхээр ажилласан.<br>6. НЗД-ын нэгдүгээр орлогч М.Даваадалайн хамт Өргөө зочид буудлын гадна мэдэгдэл хүргүүлж, олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан<br>7. НЗД-ын 2025 оны А/1297 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 3-р хуралд Хүнс хангамжийн 4 ОНӨААТҮГ-ын санхүү тайлангийн шинжилгээг бэлтгэж танилцуулсан.<br>8. НЗД-ын 2025 оны А/266 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дарга НЗДТГ-ын даргад “Дун өргөө” ХХК-ийн танилцуулгыг хийх зорилгоор, мөн тус компанийн 2013-2025 оны татварын тайлангийн мэдээллийн НТГ-аас гаргуулж боловсруулан үйл ажиллагаа эрхлээд олсон орлогыг тооцоолж гаргах ажлыг хийсэн. Ажлын хэсэг 2025 оны 11 сарын 28-ны өдөр “Хар дун” ХХК-ийн төлөөлөлтэй эхний уулзалтыг хийсэн. | |
| 11. | Арга хэмжээ 2.3 /3.3/ | | | | | | “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НЗДТГ Монгол Улсын сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 0% | 100% | худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагаанд оролцсон. Үүнд:<br>1. НӨХГ-ын тээврийн хэрэгсэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр 28,500,000.0 төгрөгийн тендерийг зарласан. 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр тендер нээж оролцогч санал ирүүлээгүй байна.<br>2. 2025 оны 12 сарын 01-ний өдөр дахин (tender.gov.mn)-ээр зарласан. | 100%<br>70 |
| 12. | Арга хэмжээ 2.4 /3.4/<br>2025 оны нийслэлийн “Бүтээн байгуулалтын жил”-ийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | 2025 оны 03 дугаар сарын 28-ны 02-02/1865 дугаартай албан бичгээр ирүүлсэн Нийслэл хотод хэрэгжүүлэх 24 мега төслийн танилцуулгын хүрээнд албан хаагчид болон олон нийтэд үнэн, зөв мэдээллийг үе шаттайгаар танилцуулах төлөвлөгөөг гаргаж, 2025 оны 03 сарын 31-ний өдрийн сургалтаар “Түгжрэлийг бууруулах ажил”-ын хүрээнд хийгдэх 10 мега төсөл, 2025 оны 04 сарын 07-ны өдрийн сургалтаар “Агаарын бохирдлыг бууруулах” ажлын хүрээнд хийгдэх 6 мега төсөл, 2025 оны 04 сарын 11-ний өдрийн сургалтаар “Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх” ажлын хүрээнд хийгдэх 8 мега төслийн танилцуулгыг хийж, тайланг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 1/568 дугаарт албан бичгээр Нийслэлийн Засаг Даргын тамгын газарт хүргүүлсэн болно. Мөн сургалт зохион байгуулагчдын зүгээс Мега төслүүдийн танилцуулын талаар нийт албан хаагчдын дунд сэтгэл ханамжийн судалгааг https://docs.google.com/forms ашиглаж авахад | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төслийн танилцуулга сургалтын явц, сургалтын материал болон заах аргын талаар нийт сургалтад хамрагдагсад маш сайн үнэлгээгээр дүгнэсэн судалгааны үр дүн гарсан.<br><br>Нийслэлийн зүгээс 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбоотой 24 мега төслийн талаарх Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны https://ulaanbaatar.mn/home цахим хуудсанд байршуулсан танилцуулагыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын вэб сайт https://www.umch.ub.gov.mn/ болон https://www.facebook.com/umch.ub.gov.mn FACEBOOK цахим хуудсаар дамжуулан мэдээллийг олон нийтэд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар хүргүүлэн ажиллаж байна. | |
| 13. | Арга хэмжээ 2.5 /3.5/<br><br>Байгууллагын үйл ажиллагаанд MNS ISO 9001:2016 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | Энэхүү стандарт нь хэрэглэгч буюу үйлчлүүлэгчийнхээ шаардлагыг тогтвортой хангаж, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд хэрхэн ажиллахыг тогтоосон стандарт юм.<br><br>Чанарын менежментийн зарчимд:<br><br>✓ Хэрэглэгчид төвлөрөх<br>✓ Манлайлал<br>✓ Хүмүүсийг оролцуулах<br>✓ Үйл явцын хандлага<br>✓ Сайжруулалт<br>✓ Нотолгоонд үндэслэсэн шийдвэр гаргах<br>✓ Харилцааны менежмент<br><br>Дээрх зарчмуудаас нэн тэргүүнд харилцааны менежментэд анхаарч ажиллаж байна. Учир нь шинээр ажилд орсон ажилтнуудын хувьд бусад туршлагатай албан хаагчдаас сурах зүйл маш их байдаг. Иймд харилцаа, хандлага сайтай байснаар хамт олонтойгоо хурдан ойлголцох, ажлын талаарх туршлагыг судлахад чухал нөлөө үзүүлж байна. | 100%<br><br>O |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14. | Арга хэмжээ 2.6 /3.6/<br><br>Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, "Үнэлгээний баг"-т орж ажиллах | | Үнэлгээ хийлгэх албан хаагчдын тоо | 0% | 0% | 100% | Тухайн төлөвлөөний дагуу хийгдсэн ажил байхгүй байна. | 100% |
| 15. | Арга хэмжээ 2.7 /3.7/<br><br>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих | | Модны тоо, Өртөг, сая төг | 0% | 50% | 100% | Хэлтэс бүрэлдэхүүнээрээ мод тарих үйл ажиллагаанд гар бие оролцсон. | 100% |
| 16. | Арга хэмжээ 2.8<br><br>Албан хаагчийн албан үүргээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцох | | Сургалт, семинар,<br><br>Албан хаагчдын тоо | 0% | 50% | 100% | ***1) Долоо хоног бүр цахимаар тогтмол***<br>Төрийн албаны зөвлөлөөс цахим хэлбэрээр зохион байгуулдаг 7:4:10 сургалтууд;<br>2) ***2025-04-27-28 цахимаар***<br>Компанийн засаглалын сургалт<br>***3) 2025-04-11 цахимаар***<br>"Бүтээмж ба шийдэл" мэтгэлцээний 4 дүгээр тэмцээний техникийн зөвлөгөөн, сургалт;<br>***4) 2025-06 сар***<br>Удирдлагын академи Монгол бичгийн анхан шатны сургалт №731282<br>***5) 2025-05 сар***<br>Удирдлагын академи Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалт №731301<br>***6) 2025-06 сар***<br>Удирдлагын академи Төрийн албан хаагчдад зориулсан "Ёс зүй" анхан шат сургалт №732009<br>***7) 2025-03-13-14 нд танхимаар***<br>Удирдлагын академиас зохион байгуулсан "Байгууллагын зэрэг соёлыг бүрдүүлэх нь" сургалт<br>***8) 2025-05-05-09 танхимаар***<br>"Төрийн болон Орон нутгийн өмчийн 2025 оны тайлан, мэдээ нэгтгэл" сэдэвт сургалт<br>***9) 2025-01-06 танхимаар*** | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | АТГ-аас зохион байгуулсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан”-ны сургалт;<br>***10) 2025-04-30 танхимаар***<br>Нийслэлийн Засаг захиргааны нэгжийн шинэчлэл ба Хот тосгоны эрх зүйн байдлын хуулийн танилцуулга сургалт;<br>***11) 2025-04-30 танхимаар***<br>4 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдад хийх сургалт;<br>***12) 2025-04-19 танхимаар***<br>“Бүтээмж ба шийдэл” мэтгэлцээний 4 дүгээр тэмцээнд гуравдугаар байр;<br>***13) 2025-02-12 танхимаар***<br>НЗДТГ-аас зохион байгуулсан “Хос бичгээр албан хэрэг хөтлөх” сургалт<br>***14) 2025-05-13-14 танхимаар***<br>Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөлөөс зохион байгуулсан 16 цагийн чиглүүлэх сургалтуудад тус тус хамрагдсан болно.<br>***15) 2025-04-23 танхимаар***<br>“Захиргааны шийдвэр ба хүний эрх, Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам талаар ойлголт олгох, хэрэгжилтийг хангах” зорилготойгоор зохион байгуулсан 8 цагийн сургалт;<br>***16)*** 2025-11-10 танхимаар<br>НИТХ-ын Засаглал, эрх зүйн хорооны хэлэлцүүлэг<br>***17)*** 2025-10 сар МУЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг, Удирдлагын академийн Эрхэлсэн түшмэлийн сургалтад хамрагдаж төгссөн. Сертификат №Е1781 | |
| Зорилт 3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 17. | Арга хэмжээ 3.1 /5.2/ | | Үйл ажиллагааны | | | | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Ёс зүйн хэм хэмжээ батлах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НЗДТГ Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ. | | хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | тухай" 109 дүгээр тогтоолын хавсралтаар "ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ"-г баталсан. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолыг хүчингүй болсон тул Ёс зүйн дэд хорооноос албан хаагчиддаа мэдээлэл хүргэх үүднээс танхимын сургалтыг зохион байгууллаа.<br>Нийт албан хаагчдад Засгийн газрын тогтоол, тогтоолын хавсралтын линк, сургалтын материалыг файл хэлбэрээр албан ёсны цахим группэд байршуулав. | 100% |
| Зорилт 4. Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл технологийг сайжруулна. | | | | | | | | |
| 18. | Арга хэмжээ 4.1 /6.1/<br><br>Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг хангаж ажиллах | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилсан байна. Тус хуулийн 7.2-т "Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ" гэж заасан байдаг. Иймд өдөр тутмын үйл ажиллагаандаа хязгаарлалттай болон хаалттайгаас бусад мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй өгч ажилллаж байна. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын https://www.umch.ub.gov.mn/ албан ёсны цахим хуудасны **Хууль эрх зүй** цэсэнд байрлах хууль, журам, дүрмийн жагсаалтыг холбогдох мэргэжилтэнд гаргаж өгсөн. Мөн цахим хуудсыг мэдээллээр хангах ажлыг цаг тухай бүрт хийж гүйцэтгэж байна. | 100% |
| 20. | Арга хэмжээ 4.2 /6.3/<br><br>Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг хангаж ажиллах; | | Үүрэг даалгаварын тоо | 0% | 50% | 100% | Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар. Үүнд:<br>Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд байрлалтай, соёлын биет өв, улсын хамгаалалтын зэрэглэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Дамбадаржайлин хийд, түүний дагалдах эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хадгалж, хамгаалах, сэргээн засварлах, түүх, соёл, шашны цогцолбор болгон хөгжүүлэх зориулалтаар ашиглуулж, ашиглахтай холбоотой Нийслэлийн соёл урлагийн газартай нийслэлийн өмчийн ашиглуулах гэрээ байгуулахаар бэлтгэл ажилдаа орсон байна. Ашиглалтын гэрээний хавсралтад тус хийдийн өмч хөрөнгийг хүлээлцэх комиссийн бүрэлдэхүүнд Соёлын өвийн үндэсний төвөөс Авран хамгаалах, эрсдэлийн судлагааны газрын дарга Г.Анхсанаа, Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газрын Архитектурын зураг төслийн мэргэжилтэн Ч.Болорчимэг нарыг зөвшилцсөнөөр оролцуулахаар нэр ирүүлсэн байна. Гэвч өмч ашиглалтын гэрээ хийгдэхээргүй болж НЗД-ын 2025 оны А/1530 захирамжаар байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлаас "Дамбадаржаа" ОНӨААТҮГ байгуулах болсон тул НИТХ-д өргөн барих тогтоолын төслийг үүсгэн байгуулах дүрмийн хамт бэлтгэж ажилласан. | |
| Зорилт 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана. | | | | | | | | |
| 20. | Арга хэмжээ 5.1 /7.5/<br><br>Хэлтсийн болон албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, тайлагнах | | Нэгж, албан хаагчдын тоо,<br><br>Гүйцэтгэлийн хувь | 0% | 50% | 100% | Албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулав. | 100% |
| Зорилт 6. Албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулна. | | | | | | | | |
| 21. | Арга хэмжээ 6.1 /9.1/<br><br>Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж, монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэн, албан хэргийг | | Албан бичиг, өргөдөл гомдлын тоо, хэрэгжилтийн хувь | | 50% | 100% | 1. Хэлтэст ирсэн 97 албан бичиг ирсэн байна. Нийт 97 албан бичгийг шийдвэрлэсэн. https://edoc.ulaanbaatar.mn/#/Screen/ED10038/1764590434<br>2. Хэлтсээс 107 албан бичгийг холбогдох хууль журмын дагуу боловсруулж хүргүүлэн ажилласан байна. https://edoc.ulaanbaatar.mn/#/Screen/ED10039/1764590439 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хос бичгээр хөтлөн, албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх | | | | | | 3. 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Иргэн Ж.Дамчаагийн ирүүлсэн гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 4/183, 4/185 дугаар албан бичгээр хариуг баталгаат шуудангаар гэрийн хаягт хүргүүлж, харилцах утасны дугаарт гомдлыг хариуг хүргүүлсэн талаарх мэдээллийг хүргэсэн. | |
| 22. | Арга хэмжээ 6.2 /9.3/<br><br>Архивын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0% | 50% | 100% | 1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 сарын 14-ний А/486 дугаарт захирамжаар байгуулагдсан Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурал 2025 оны 04 сарын 30-ны өдөр хуралдаж НӨХГ-аас Төрийн архивт 561 хадгаламжийн нэгжийг шилжүүлэх, 2638 хадгаламжийн нэгжийн бүртгэлийн баталгаажуулж байгууллагын архивт хадгалах, 779 хадгаламжийн нэгжийг устгах жагсаалтыг батлуулахаар асуудал оруулж, хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.<br>2. Хэлтсийн дарга нарын 2024 оны жилийн эцсийн тайлан, биелэлт, үнэлгээний хуудас зэрэг баримтуудыг хадгаламжийн нэгж болгон байгууллагын архивт 1 боть хүлээлгэн өгсөн.<br>3. Мөн мэргэжилтнүүдийн 2024 оны жилийн эцсийн тайлан, биелэлт, үнэлгээний хуудас зэрэг баримтуудыг хадгаламжийн нэгж болгон байгууллагын архивт 3 боть хүлээлгэн өгсөн. | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Хууль зүйн хэлтсийн дарга ................................ / Б.Баясалмаа / 2025-12-01

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Нийслэл, орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системийн ажлын хэсэгт ажиллах | | | | "Нийслэлийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын системийг хөгжүүлэх" төслийн ажлыг 2024-05-20-ны өдрөөс хэрэгжүүлэн НЗДТГазар захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Системийн ажлын даалгаварын 4 үе шатыг товч дурдвал:<br>• Эхлэлийн тайлан<br>• Тоног төхөөрөмж нийлүүлэлт<br>• Явцын тайлан<br>• Гэрээ дүгнэсэн хаалтын тайлан гэж 4 хуваасан.<br>2025 оны 3 -р сард Системийн гүйцэтгэгч Ухаалаг шийдэл ХХК-аар НӨХГ-н албан хаагчдад сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж нийт 5 удаагийн танхимын сургалтыг, хуулийн этгээдэд танхимын сургалтыг 1 удаа хийлгэсэн байна. Систем хүлээн авах, гэрээ дүгнэх ажил хүлээгдэж Захиалагч НЗДТГ-аас ажлын даалгаварын ажилбар бүрээр гүйцэтгэлийг тулгалт хийж дотооддоо ашиглахаар хүлээж авсан байна. 2025 оны 12 сарын 01-нийи өдөр НЗД-аас нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудын ашиглаж байгаа болон ашиглахгүй байгаа системийн танилцуулгыг хийх үүрэг даалгавар өгсний дагуу "Нийслэлийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын систем"-ийн хэрэгжилт эхэлсэн цагаас өнөөдрийг хүртэлх үйл ажиллагаа, хийгдсэн ажлыг нэгтгэж танилцуулга бэлтгэж НӨХГ-ын даргад хүлээлгэн өгсөн. | 2025.01.02-12.01 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, мэдлэг сорих арга хэмжээнд оролцоно. | Амжилтын тоо | | Байр эзлэх | Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойг угтан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулах “Бүтээмж ба шийдэл” мэтгэлцээний тэмцээнд багаараа оролцож гуравдугаар байранд шалгарсан. | 2025.05.28 | 100% |
| 2 | Арга хэмжээ 2. МУЗГ-ын хэрэгжүүлэгч Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуульд суралцана | Эрхэлсэн түшмэлийн сургалтад хамрагдсан тоо | | Тус онд төгссөн байх | Удирдлагын академийн төрийн албан хаагчийн Эрхэлсэн түшмэлийн сургалтад элсэн суралцаж төгссөн. №E1781 | 2025.10.28 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Хууль зүйн хэлтсийн дарга .............................. / Б.Баясалмаа / 2025-12-01